



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Монгол Улс,
Улаанбаатар хот-210648, Ш/Х-187, Сүхбаатар Дүүрэг, 1-
р хороо, Энхтайвны гудамж-13Б
Утас: 70128801, Факс: 70128801
Цахим шуудан: admin@hdc.gov.mn
Цахим хуудас: hdc.gov.mn

2026.03.20 № 305

танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАР, ТӨРӨЛЖСӨН
МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ
МЭРГЭЖЛИЙН ТӨВ, ХУВИЙН
ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, ЗАХИРАЛ
ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар бүлэг 25 дугаар зүйлийн 25.16-д “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтын болон мэргэшлийн зэргийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам, мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам, мэргэшлийн зэргийн болон төгсөлтийн дараахь сургалтыг төгсөгчид олгох үнэмлэх, гэрчилгээний загварыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан.

Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн сайд “Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ыг 2019 оны 513 дугаар тушаалаар баталж эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаанд мөрдүүлж байна.

Энэхүү журмын 9.4-т мэргэжлийн зэргийн хүчинтэй хугацааг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

1. 9.4.1 ахлах, тэргүүлэх зэрэг нь анх олгосноос хойш тухайн мэргэжил, мэргэшлээр тасралтгүй ажиллаж байгаа нөхцөлд 10 жил;

2. 9.4.2 журмын 9.4.1-д заасны дагуу мэргэжил, мэргэшлээр тасралтгүй 10 жил ажилласны дараа 1 удаа тухайн мэргэшлийн зэргийг давтан хамгаалах шаардлагатай бөгөөд амжилттай давтан хамгаалсан нөхцөлд тухайн мэргэжил, мэргэшлээр цаашид тасралтгүй ажиллаж байгаа бүхий л хугацаанд;

3. 9.4.3 зөвлөх зэрэг олгосноос хойш тухайн мэргэжил, мэргэшлээр тасралтгүй ажиллаж байгаа бүхий л хугацаанд” гэж тус тус заасан тул хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Харин Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчийн мэргэшлийн зэргийг 5 жил тутамд шинэчлэн тогтооно” гэж заасан

нь Эрүүл мэндийн хуулийн 25.16-д өөрөөр заасан тул хамаарахгүй болно.

Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэргийн гэрчилгээг 2023 оноос эхлэн Эрүүл мэндийн ажилтны бүртгэл мэдээллийн нэгдсэн сан hr.hdc.gov.mn программд цахим хэлбэрээр олгогдож байгаа бөгөөд хүчинтэй хугацаа нь 10 жилээр бүртгэгдсэн.

Иймд 2021, 2022 онд олгогдсон цаасан гэрчилгээн дээр 5 жилээр бичигдсэн хугацаа нь Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журмын 9.4-т заасан хугацаагаар хүчинтэй хэвээр байх тул эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тасралтгүй олгоход дэмжлэг үзүүлж ажиллана уу.

Хүндэтгэсэн,



Эрүүл мэндийн хөгжлийн төв
Захиргааны алба
Захиргааны албаны дарга
Батбаяр Доржмягмар
2026-03-20 11:53:30